



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 1100

Улаанбаатар хот

Тарваган тахал өвчний болзошгүй
дэгдэлтийн бэлэн байдал, хариу арга
хэмжээг эрчимжүүлэх тухай

Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, 8.1.13, 8.1.21 дэх заалт, Тарваган тахал өвчний оношилгоо, эмчилгээ, тандалтын Монгол улсын стандарт (MNS:5348-41:2010)-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тарваган тахал өвчний бэлэн байдлыг хангах ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, тарваган тахал өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцөд нэмэлтээр шаардлагатай эм урвалж, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын тооцоог гаргаж, шийдвэрлүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

2. Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдэх үед тусгаарлах эмнэлэг, өрөө, лабораторийн сорьц авах хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, эм тариа, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх, мэргэжлийн багийг томилгоожуулах, сургалтад хамруулах, голомтот нутгийн хүн амд хийх мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, "Тарваган тахал, боом, галзуу өвчинтэй тэмцэх арга хэмжээний заавар батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2008 оны 151 дугаар тушаалыг чанд мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Нийслэлд тарваганы түүхий эд, бүтээгдэхүүн нэвтрэн орж ирэхээс сэргийлэх, эрсдэлтэй газруудад идэвхтэй тандалт судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийх, хөдөлгөөнт эргүүл, хяналтыг эрчимжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/ нарт үүрэг болгосугай.

4. Тарваган тахал өвчний мэдээ, мэдээллийн шуурхай байдлыг хангах, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээ хийх, мэргэжил, арга зүйгээр ханган мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн /Б.Цогтбаатар/ нарт үүрэг болгосугай.

080083

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллахыг Дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ